



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 01/422

Улаанбаатар хот

Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн  
газрын эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 7,826,000 /долоон сая найман зуун хорин зургаан мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар /Т.Дамбийням/-т зөвшөөрсүгэй.


2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс, 4 нэр төрлийн 7,826,000 /долоон сая найман зуун хорин зургаан мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар /Т.Дамбийням/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.


ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ



115050001015

Нийслэлийн Өмнийн ашиглалт, удирдлагын газрын  
 даргын 2020 оны 07 дугаар сарын 30 өдрийн  
 0/422 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн газар

/төгрөгөөр/

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХ Комиссын шийдвэр
Машин тоног төхөөрөмж												
1	Гар станц ТК-2217	5	Ш	21	264,000.00	5,544,000.00	5,544,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах
2	Гар станц	5	Ш	7	275,000.00	1,925,000.00	1,925,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах
3	Принтер 1010	4	Ш	1	297,000.00	297,000.00	297,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах
4	Тоос сорогч	3	Ш	1	60,000.00	60,000.00	60,000.00	-	эвдэрсэн	актлах	татах	татах
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						7,826,000.00	7,826,000.00	-				
Үүнээс: татан төвлөрүүлэх хөрөнгө						7,826,000.00	7,826,000.00	-				